

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 23

Дугаар 08

Улаанбаатар хот

Компанийн гүйцэтгэх захиралыг чөлөөлөх, томилох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.9-р заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.7, 9.2.12.8-р заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Компанийн гүйцэтгэх захирал Ж.Ганхүлэг /ФА90030416/ нь өөрийн хүсэлтээр ажлаас гарах тухай хүсэлт гаргасан тул тус хүсэлтийг үндэслэн 2024 оны 4-р сарын 19-ний өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
- Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Батжаргал овогтой Бадамцэцэг /РД:МБ83120301/-ийг 2024 оны 4-р сарын 23-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэх захирлаар томилсугай
- Ж.Ганхүлэгийн гүйцэтгэж байсан ажил үүрэг, бусад холбогдох баримт материал, эд хөрөнгийг 2024 оны 4-р сарын 23-ны өдрөөс 2024 оны 4-р сарын 26-ны өдрийн хооронд актаар хүлээлцэхийг Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.
- Компанийн гүйцэтгэх захирал өөрчлөгдөж байгаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, УБЕГ болон бусад хамтран ажилладаг байгууллагуудад мэдэгдэн, мэдээллээ шинэчлэн ажиллахыг Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.
- Компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалд түр томилогдон ажиллах Б.Бадамцэцэгт Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм болон бусад холбогдох журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Ч.ЧИНЗОРИГ



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 23

Дугаар 09

Улаанбаатар хот

Компанийн салбар нэгж байгуулах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 7.11 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.14 дэх заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын 11 дугаар тоот тогтоол, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.14 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааг тэлэх, харилцагчдад хүрч үйлчлэх үүднээс компанийн салбар нэгж байгуулан ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.
2. Компанийн салбарын захирлаар Цэдэндорж овогтой Билэг-Өрнөх /РД:МО74042600/-ийг 2024 оны 5-р сарын 1-ний өдрөөс эхлэн нэг сарын цалинг 2,500,000 төгрөгөөр тогтоосугай.
3. Салбарын үйл ажиллагаанд мөрдөх журмыг Хавсралт №1, Шаардлагатай тоног төхөөрөмж, харуул хамгаалалтын зардалуудыг Хавсралт №2-р баталсугай.
4. Салбарын захирал Ц.Билэг-Өрнөхөд Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм болон бусад холбогдох журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Ч.ЧИНЗОРИГ



ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 4-р сарын 23

Дугаар 10

Улаанбаатар хот

Хуулийн компанитай хамтран ажиллах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Компанийн дүрмийн 9-р зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- Компанийн хаалттай хүрээнд нэмж энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор хуулийн компанитай гэрээ хэлцэл хийн хамтран ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт олгосугай.
- Хуулийн байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжыг бүрдүүлж, баримт материал, шаардлагатай мэдээлэлээр ханган ажиллахыг гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ